



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/327

Хэрлэн сум

Донорын өдөрлөг зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Донорын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүндэт доноруудыг алдаршуулах "Донорын өдөр"-ийг зохион байгуулахад хэрэглэх хэвлэлийн зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ